



Хэвлэлийн мэдээ
2016 оны 6-р сарын 30-ны өдөр, Пүрэв гараг

Холбогдох утас:
9710-9009

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим болон Америкийн Худалдааны Танхим Хамтран Дугуй Ширээний Уулзалт Зохион Байгуулав

Вашингтон, Д.С. - Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам) болон Америкийн Худалдааны Танхим хамтран “Монгол улс эргэн ирлээ: Америкийн хувийн хэвшлийнхэнд гарч буй боломжууд” сэдэвт дугуй ширээний уулзалтыг 2016 оны 6-р сарын 24-ний Баасан гарагт Вашингтон хотод байрлах Америкийн Худалдааны Танхимд Оюу Толгой ХХК-ийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Энэхүү уулзалтад АНУ-ын төрийн албан тушаалтнууд, АНУ дахь Монгол улсын Элчин Сайдын Яамны төлөөлөгчид, АмЧам Монголын болон Ази Номхон Далайн Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөлийн төлөөлөл (АПКАК), бизнесийн салбарын төлөөлөл болон бусад холбогдох талуудаас бүрдсэн 35 гаруй төлөөлөгчид оролцлоо.

Тус уулзалт нь АмЧам Монголын АНУ руу хийж буй гурав дахь удаагийн Бизнес Аялалын хүрээнд зохион байгуулагдсан бөгөөд уулзалтын үеэр Монгол улсын бизнесийн салбарын өнөөгийн нөхцөл байдал болон АмЧам Монголын зүгээс Америк-Монгол улсын худалдаа арилжааны хамтын ажиллагааг улам өргөжүүлэх чиглэлээр Америкийн Худалдааны Танхим болон АПКАК-ийн хамт хийж хэрэгжүүлж буй ажлуудын талаар санал солилцсон юм.

Америкийн Худалдааны Танхимын Азийг хариуцсан Дэд Ерөнхийлөгч хагагтай Тами Өвербай АмЧамын эрхэм зорилгын чухлыг онцлон дурдаж хэлэхдээ “АНУ-ын Худалдааны Танхим нь Монгол улсыг АНУ-ын улс төрийн болон эдийн засгийн чухал түнш гэж үздэг. Бид хоёр улсын хоорондын худалдааны харилцааг өргөжүүлэх, гишүүддээ үйлчлэх АмЧамын зорилгыг дэмжиж ажилладаг ба цаашид энэ харилцааг улам гүнзгийрүүлэхийн төлөө ажиллах болно” гэсэн юм.

“Ази Номхон Далайн Орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл (АПКАК) нь АмЧам Монголын гишүүдийг Ази-Номхон далайн бусад 28 орны АмЧамуудтай холбох гүүр болж ажилладагаараа чухал ач холбогдолтой юм. АмЧам-АПКАК-Америкийн Худалдааны Танхим гэсэн түншлэл нь гишүүн байгууллагуудынхаа ашиг сонирхлын төлөө үйлчлэх хүчирхэг багийг бий болгож байна” хэмээн АПКАК-ын ТУЗ-ийн дарга бөгөөд АмЧам Монголын ТУЗ-ийн гишүүн ноён Жаксон Кокс уулзалтын үеэр онцлон тэмдэглэсэн юм.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны оффис юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.